



**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН  
ТОГТООЛ**

2019 оны 2 дугаар  
сарын 13-ны өдөр

Дугаар 69

Улаанбаатар  
хот

Үндэсний хөтөлбөр батлах тухай

Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 10.3-т заасныг үндэслэн Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Чулуун соёлын өв" үндэсний хөтөлбөрийг хавсралт ёсоор баталсугай.
2. "Чулуун соёлын өв" үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг баталж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ө.Баатарбилэгт үүрэг болгосугай.
3. "Чулуун соёлын өв" үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлахад шаардагдах хөрөнгийг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын төсвийн багцад жил бүр тусган, олон улсын байгууллага, гадаадын зээл туслаамжид хамруулах, хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх замаар санхүүжүүлэх арга хэмжээ авахыг Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ө.Баатарбилэг нарт даалгасугай.



Монгол Улсын Ерөнхий сайд

У.ХҮРЭЛСҮХ

Боловсрол, соёл, шинжлэх  
ухаан, спортын сайд

Ө.БААТАРБИЛЭГ



МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ,  
СОЁЛ, ШИНЭКЛЭХ УХЛАН, СПОРТЫН  
САЙДЫН ТУШААЛ

2019 сны 06 сарын 05 одир

Дугаар 4/568

Улаанбаатар хот

Төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны "Үндэсний хөтөлбөр батлах тухай" 69 дүгээр тогтоолын 2 дахь хэсэгт заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1."Чулуун соёлын өв" үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

2.Төлөвлөгөөнд туссан арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг жил бурийн төсөвт тусгуулах арга хэмжээ авахыг Санхүү, хөрөнгө оруулалтын газар /С.Нансалмаа/-т, салбар дундын зохицуулалт хийж, мэргэжлийн удирдлагаар хангаж ажиллахыг Соёл, урлагийн бодлогын газар /Б.Сэргэлэн/-т төлөвлөгөөнд туссан арга хэмжээний хэрэгжилтийг хангаж ажиллахыг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёл, урлагийн газар /Г.Эрдэнэбат/-т, сэргээн засварлах ажлыг мэргжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Соёлын евийн үндэсний төв /Г.Энхбат/-д тус тус даалгасугай.


3.Төлөвлөгөөнд туссан арга хэмжээний биелэлтэд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийж, холбогдох журмын дагуу хугацаанд нь Засгийн газарт танилцуулахыг Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /З.Энхболд/-т даалгасугай.

САЙД



Е.БААТАРБИЛЭГ

301105



## “ЧУЛУУН СОЁЛЫН ӨВ” ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР

### Нэг. Нийтлэг үндэслэл

Чулуун соёлын өв нь хүн төрөлхтний хөгжлийн түүхийн тодорхой цаг үеийн гарч болон үлдэж, хүмүүсийн нийгмийн байдал, оюуны соёлын түвшин, зан заншил, шашин шүтлэг болон ахуй амьдралын улирч мартагдсан түүхийг нэхэн сэргээж ойлгох гол эх сурвалж болдог, дэлхий нийтийн үнз цэнэтэй дурсгал юм.

Монгол Улсын Үндсэн хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монголын ард түмний түүх, соёлын дурсгалт зүйл, шинжлэх ухаан, оюуны өв терийн хамгаалалтад байна” гэж, Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”ын 1.1.6-д “Үндэсний түүх, хэл, соёл, өв уламжлал, зан заншилаа хадгалж, хамгаалж хөгжүүлэх нь монгол үндэстний оршин тогтонохиын үндэс, амин чухал дархлаа мен” гэж, Улсын Их Хурлын 2012 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Төрөөс соёлын талаар баримтлах бодлого”ын 4.3.2-т “эрт эдүгээгийн соёлын өв санг үндэсний эрхэм баялаг болохын хувьд терийн хамгаалалтад байлгах” гэж тус тус заасан байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны “Хадны зураг, бичээсийг хамгаалах, судлах ажлыг дэмжих тухай” 181 дүгээр зарлигт хадны зураг, бичээсийг хадгалж хамгаалах, дэлхий дахинаа сурталчлан таниулах, аялал жуулчлалын шинэ хэлбэрийг хөгжүүлэх зорилгоор өргөн хүрээтэй, үр дүнтэй ажил зохион байгуулахыг бүх шатны засаг захиргааны байгууллагууд, териин болон териин бус байгууллага, шинжлэх ухаан, нийгэм соёлын зүтгэлтнүүд, аялал жуулчлалын байгууллага, ард иргэдэд уриалсан байна.

2015 онд улсын хэмжээнд явуулсан үзлэг, тооллогын дүн мэдээгээр манай улсын нутаг дэвсгэр дээр 4230 хөшөө чулуу, 6796 хадны зураг, бичгийн дурсгал бүртгэгдсэний ихэнх нь байгаль, нийгмийн хүчин зүйлийн нелөөгөөр их бага хэмжээгээр эвдэрч гэмтсэн байна. Ялангуяа цаг уурын өөрчлөлт, уул уурхай, зам харилцаа зэрэг шинэ бүтээн байгуулалт, аялал жуулчлал, шашин шүтлэгийн нелөөгөөр чулуун соёлын өвд хохирол учрах явдал түгээмэл тохиолдож байна.

Чулуун соёлын өвийг хамгаалахад өмнө тулгамдаж байгаа асуудлыг шийдвэрлэхийн тулд санхүүгийн болон хүний неөц, техник технологийн боломжид үндэслэн тодорхой дурсгалуудыг сонгон хамгаалах, сэргээн засварлах арга хэмжээг шинжлэх ухааны үндэслэлтэй боловсруулсан арга зүйн дагуу гүйцэтгэх, дурсгалыг цаашид хэрхэн хамгаалах талаар хэтийн төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх, аялал жуулчлалтай уялдуулан хөгжүүлэх, гадаад, дотоодод сурталчлах зэрэг цогц арга хэмжээ авах шаардлагатай байна.

### Хоёр. Хөтөлбөрийн зорилго, зорилт, хэрэгжүүлэх хугацаа

2.1. Монгол Улсын нутаг дэвсгэр дээр оршин байгаа түүх, соёл, шинжлэх ухааны хувьд чухал ач холбогдолтой хадны зураг, бичээс, буган чулуун хөшөө,

хүн чулуун хөшөө, тамга тэмдэг, бичээс бүхий хөшөө, амьтны дүрст чулуун дургсал, зураг, тамга бүхий хавтан чулуун дурсгалууд эзрэг чулуун соёлын өвийг бүртгэн баримтжуулах, судалж шинжлэх, хадгалж хамгаалах, сэргээн засварлах, сурталчлан таниулах, зохистой ашиглах замаар чулуун соёлын өвийн оршин тогтонох чадавхыг бэхжүүлж, хамгаалахад хөтөлбөрийн зорилго оршино.

## 2.2. Хөтөлбөрийн хүрээнд дараах зорилтыг хэрэгжүүлнэ:

- 2.2.1. Чулуун соёлын өвийг бүртгэн баримтжуулах;
- 2.2.2. Чулуун соёлын өвийг хамгаалах, сэргээн засварлах;
- 2.2.3. Чулуун соёлын өвийг сурталчлах;
- 2.2.4. Чулуун соёлын өвийг түшиглэсэн аялал жуулчлалын шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгох.

## 2.3. Хөтөлбөрийг 2019-2024 онд хэрэгжүүлнэ.

Гурав. Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа

3.1. Чулуун соёлын өвийг бүртгэн баримтжуулах зорилтын хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

- 3.1.1. чулуун соёлын өвийг бүртгэн баримтжуулах, мэдээлэл цуглуулах арга зүйг боловсронгуй болгох;
- 3.1.2. чулуун соёлын өвийг бүртгэн баримтжуулах ажлыг дурсгалын тэрлөөр бүсчлэн зохион байгуулах;
- 3.1.3. зарим томоохон цогцолбор дурсгалын оршин байгаа газрыг кадастрын улсын бүртгэлд бүртгүүлэх;
- 3.1.4. зарим цогцолбор дурсгалыг Дэлхийн соёлын өвийн жагсаалтад нэр дэвшүүлэх.

3.2. Чулуун соёлын өвийг хамгаалах, сэргээн засварлах зорилтын хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

- 3.2.1. чулуун соёлын өвийн хэв, дардасыг авах, хуулбарыг хийж хадгалах;
- 3.2.2. чулуун соёлын өвийг цэвэрлэж бэхжүүлэх, сэргээн засварлах;
- 3.2.3. чулуун соёлын өвийн хамгаалалтын хайс, хаашаа барьж, танилцуулга байрлуулах;
- 3.2.4. чулуун соёлын өвийн устах эрсдэлд орсон дурсгалыг унаган газраас нь зөвхөн тээвэрлэн аюулгүй газарт шилжүүлэн байрлуулах;
- 3.2.5. чулуун соёлын өвийн чулуулгийн бутцийн болон эвдрэл гэмтлийг нарийвчлан судалж тодорхойлох лаборатори байрлуулах.

3.3. Чулуун соёлын өвийг сурталчлах зорилтын хүрээнд дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

3.3.1. чулуун соёлын өвийн талаар баримтат кино бүтээж сурталчлах;

3.3.2. судалгаа, сурталчилгааны ном, бүтээл хэвлүүлэх;

3.3.3. дотоод, гадаадад тусгай үзэсгэлэн зохион байгуулах.

3.4. Чулуун соёлын өвийг түшиглэсэн аялал жуулчлалын шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгох зорилтын хүрээнд дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

3.4.1. чулуун соёлын өвийн талаар хетеч, тайлбарлагчдын мэдлэгийг дээшлүүлэх;

3.4.2. зарим томоохон цогцолбор дурсгалыг түшиглэн музей, ил үзвэрийн газар байгуулах;

3.4.3. чулуун дурсгалыг түшиглэсэн аяллын маршрут бий болгож хөгжүүлэх;

#### Дөрөв. Хөтөлбөрийн хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлт

№	Зорилт	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин		Зорилтот түвшин	
				Он	Үзүүлэлт	Он	Үзүүлэлт
Бодлогын баримт бичгийн үр дүнг үнэлэх бусад шалгуур үзүүлэлтүүд							
1	1. Чулуун соёлын өвийг бүртгэн баримтжуулах	шинэ арга зүйгээр бүртгэл хийж, цахим хэлбэрт нэвтрүүлсэн байдал	тоо	2019	11026	2024	12000
		бүртгэн баримтжуулсан дурсгал	тоо	2019	3000	2024	5000
		кадастрын бүртгэлд бүртгэгдсэн байдал	тоо	2019	-	2024	10
		дэлхийн соёлын өвд нэр дэвшиүүлж, бүртгэгдсэн өв	тоо	2019	3	2024	5
2	2. Чулуун соёлын өвийг хамгаалах, сэргээн засварлах	хэв, дардас, хуулбар авч хадгалсан өв	тоо	2019	8	2024	20
		сэргээн засварлаж, цэвэрлэж бэхжүүлсэн өв	тоо	2019	20	2024	27
		хамгаалалтын хаашаа, танилцуулга самбар байршуулсан өв	тоо	2019	8	2024	14
		аюулгүй газарт шилжүүлсэн	тоо	2019	12	2024	17

		байдал					
		тоног төхөөрөмж, лабораторийн хүчин чадал	хувь	2019	10%	2024	50%
3	3. Чулуун соёлын евийг сурталчлах	баримтат кино бүтээл	тоо	2019	3	2024	7
		хэвлэгдсэн ном бүтээл	тоо	2019	10	2024	25
		зохион байгуулсан үзэгслэл	тоо	2019	-	2024	3
4	4. Чулуун соёлын евийг тушиглэсэн аялал жуулчлалын шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгох	хэвлүүлсэн гарын авлагы	тоо	2019	-	2024	250
		шинээр байгуулсан музей	тоо	2019	-	2024	2
		шинээр бий болсон маршрут	тоо	2019	-	2023	3

Тав. Хетелбериин санхүүжилт

5.1. Хетелберийг хэрэгжүүлэх санхүүжилтийг дараахь эх үүсвэрээс бүрдүүлнэ:

- 5.1.1. улсын болон орон нутгийн төсөв;
- 5.1.2. гадаадын зээл, буцалтгүй тусламж;
- 5.1.3. гадаад, дотоодын хөрөнгө оруулалт;
- 5.1.4. иргэн, аж ахуйн нэгж байгууллагын хандив;
- 5.1.5. хууль тогтоомжоор хориглоогүй бусад эх үүсвэр.

Зургаа. Хетелбериин хяналт, шинжилгээ, үналгээ

6.1. Хетелберийн хэрэгжилтэд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийх ажлыг соёлын асуудал эрхэлсэн териийн захиргааны төв байгууллага Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 10.7-д заасны дагуу жил бүр зохион байгуулж, тайланг дараа оны 1 дүгээр улиралд багтаан Засгийн газарт танилцуулна.

6.2. Соёлын асуудал хариуцсан териийн захиргааны төв байгууллага хяналт, шинжилгээ, үнэлгээний дүгнэлт, зөвлөмжийд үндэслэн хетелберийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, төлөвлөгөөнд нэмэлт, өөрчлөлт оруулах болон шаардлагатай бусад арга хэмжээ авах ажлыг зохион байгуулна.

Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах  
нийтлэг журмын 6 дугаар хавсралт

"ЧУУЛУУН СОЁЛЫН ӨВ" ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ  
АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Зорилго		Бодлого, хөтөлбөрийн зорилго						Эдийн засгийн тооцооллын дэлгэрэнгүй задаргаа		
№	Үйл ажиллагаа	Бүтээгдэхүүн	Шалгур үзүүлэлт	Хэрэгжилтийг хариуцах байгууллага	Хамтран хэрэгжүүлэх байгууллага	Хэрэгжих хугацаа	Санхүүжилт /1+2/	1. Ургсан зардал	2. Хөрөнгө оруулант	
Зорилт 1. Чулуун соёлын өвийг бүртгэн баримтжуулах;								383,500	383,500	-
1	1.1. Бүртгэн баримтжуулах, мэдээлэл цуглуулах арга зүйг боловсронгуй болгоно.	1.1.1. Чулуун соёлын өвийг бүртгэх арга зүйг шинээр боловсрууна.	Арга зүй боловсруулагдсан байдал	БСШУСЯ	СҮГ, СӨҮТ, TAX	2019	1,500	1,500	-	
2		1.1.2. Чулуун соёлын өвийн бүртгэлийн маягтыг "RICH" програмд нэвтрүүлнэ.	Маягтыг програмд нэвтрүүлсэн байдал	БСШУСЯ,	СҮГ, СӨҮТ	2019-2020	15,000	15,000	-	
3		1.1.3. Чулуун соёлын өвийн мэдээллийг "RICH" програм руу шилжүүлж хадгалахаар байдал.	Мэдээлэл хадгалаадсан байдал	БСШУСЯ,	СҮГ, СӨҮТ	2020-2024	20,000	20,000	-	
Нийт дүн								36,500	36,500	-
4	1.2. Бүртгэн баримтжуулах ажлыг дурсгалын төрлөөр бусчлан зохион байгуулна.	1.2.1. Баруун бус /Баян-Өлгий, Говь-Алтай, Завхан, Ус, Ховд/-ийн чулуун соёлын өвийг бүртгэн баримтжуулах ажлыг зохион байгуулна.	Бүртгэн баримтжуулсан дурсгалын тоо	БСШУСЯ,	СҮГ, СӨҮТ, TAX	2020-2021	40,000	40,000	-	
5		1.2.2. Хангайн бус /Архангай, Баянхонгор, Булган, Орхон, Эвэрхангай, Хөвсгөл аймгууд/-ийн чулуун соёлын өвийг шинэчлэн бүртгэн баримтжуулах ажлыг зохион байгуулна.	Бүртгэн баримтжуулсан дурсгалын тоо	БСШУСЯ,	СҮГ, СӨҮТ, TAX	2022-2023	48,000	48,000	-	
6		1.2.3. Төвийн бус /Дорнод, Сүхбаатар, Дархан-Уул, Дорноговь, Дундговь, Өмнөговь, Сэлэнгэ, Төв аймгууд/-ийн чулуун соёлын өвийг шинэчлэн бүртгэн баримтжуулах ажлыг зохион байгуулна.	Бүртгэн баримтжуулсан дурсгалын тоо	БСШУСЯ,	СҮГ, СӨҮТ, TAX	2022-2023	45,000	45,000	-	
7		1.2.4. Зүүн бус /Дорнод, Сүхбаатар, Хэнтий аймгууд/-ийн чулуун соёлын өвийг шинэчлэн бүртгэн баримтжуулах ажлыг зохион байгуулна.	Бүртгэн баримтжуулсан дурсгалын тоо	БСШУСЯ,	СҮГ, СӨҮТ, TAX	2020-2021	26,000	26,000	-	
8		1.2.5. Улаанбаатарын бус /Нийслэл, түүний дүүргүүд/-ийн чулуун соёлын өвийг шинэчлэн бүртгэн баримтжуулах ажлыг зохион байгуулна.	Бүртгэн баримтжуулсан дурсгалын тоо	БСШУСЯ,	СҮГ, СӨҮТ, TAX	2023	6,000	6,000	-	
Нийт дүн								165,000	165,000	-
9	1.3. Зарим томоохон цогцолбор дурсгалын оршин буй газрыг кадастрин улсын	1.3.1. Хөвсгөл аймгийн Бүрэнтогтох сумын нутагт орших Ушигийн өврийн буган чулуун хөшөө бүхий	Кадастрын бүртгэлд бүртгэгдсэн байдал	БСШУСЯ,	СӨҮТ TAX	2019	3,200	3,200	-	

Сүрьеэнд сургуулилж.								
10		1.3.2. Дундговь аймгийн Өлзийт сумын нутагт орших Дэл уулын хадны зураг бухий цогцолбор	Кадастрын буртгэлд бүртгэгдсэн байдал	БСШУСЯ,	СӨҮТ TAX	2020	3,200	3,200
11		1.3.3. Хантий аймгийн Баянхутаг сумын нутагт орших Сэргэн хаалганы бичээс	Кадастрын буртгэлд бүртгэгдсэн байдал	БСШУСЯ,	СӨҮТ TAX	2020	3,600	3,600
12		1.3.4. Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын нутагт орших Хаалгатын хүч чулуун хөшөө бухий цогцолбор	Кадастрын буртгэлд бүртгэгдсэн байдал	БСШУСЯ,	СӨҮТ TAX	2020	4,800	4,800
13		1.3.5. Дорнод аймгийн Халхгол сумын нутагт орших Их бурхантын цогцолбор	Кадастрын буртгэлд бүртгэгдсэн байдал	БСШУСЯ,	СӨҮТ TAX	2020	5,300	5,300
14		1.3.6. Булган аймгийн Баян-Агаад сумын нутагт орших Шивэээт улааны цогцолбор	Кадастрын буртгэлд бүртгэгдсэн байдал	БСШУСЯ,	СӨҮТ TAX	2021	3,100	3,100
15		1.3.7. Төв аймгийн Алтанбулаг сумын нутагт орших Өнгөтгийн цогцолбор	Кадастрын буртгэлд бүртгэгдсэн байдал	БСШУСЯ,	СӨҮТ TAX	2021	2,800	2,800
16		1.3.8. Булган аймгийн Бугат сумын нутагт орших Альтаадын голын Бичигч гарамны зосон зураг	Кадастрын буртгэлд бүртгэгдсэн байдал	БСШУСЯ,	СӨҮТ TAX	2021	2,600	2,600
17		1.3.9. Ховд аймгийн Манхан сумын нутагт орших Хойд Сэнхэрийн агуй	Кадастрын буртгэлд бүртгэгдсэн байдал	БСШУСЯ,	СӨҮТ TAX	2022	6,200	6,200
18		1.3.10. Архангай аймгийн Ихтамир сумын нутагт орших Тайхар чулуу	Кадастрын буртгэлд бүртгэгдсэн байдал	БСШУСЯ,	СҮГ, СӨҮТ	2019	3,600	3,600
19		1.3.10. Архангай аймгийн Өндөр-Улаан сумын нутагт орших Их Жаргалантын буган чулуун хөшөө бухий цогцолбор	Кадастрын буртгэлд бүртгэгдсэн байдал	БСШУСЯ,	СҮГ, СӨҮТ	2019	3,600	3,600
Нийт дүн							42,000	42,000
20	1.4.Зарим цогцолбор дурсгалыг Дэлхийн соёлын өвийн жагсаалтад нэр дэвшүүлэх.	1.4.1. Буган чулуун хөшөө бухий хурлийн үеийн цогцолбор дурсгалыг нэр дэвшүүлж бүртгүүлэх.	Нэр дэвшүүлж, бүртгүүлсэн байдал	БСШУСЯ, ЮМҮК	СҮГ, СӨҮТ, TAX, ТББ	2022	60,000	60,000
21		1.4.2. Говийн хадны зургийн дурсгалыг дэлхийн өвийн жагсаалтад нэр дэвшүүлж бүртгүүлэх.	Нэр дэвшүүлж, бүртгүүлсэн байдал	БСШУСЯ, ЮМҮК	СҮГ, СӨҮТ, TAX, ТББ	2024	80,000	80,000
Нийт дүн							140,000	140,000
Зорилт 2.Чулуун соёлын өвийг хамгаалах, сэргээн засварлах;							1,928,500	918,500
22	2.1. Хэв, дардасыг авч, хуулбарыг хийж хадгалах;	2.1.1.Дундговь аймгийн Дэлгэрхантай сумын нутагт орших Баруун элгэнгийн бичээсийн хэвийг авч, хуулбар хийн хадгалах	Хэв авч, хуулбар хийгдсэн байдал	БСШУСЯ	СҮГ, СӨҮТ	2019	8,000	8,000
23		2.1.2. Хантий аймгийн Батширээт сумын нутагт орших Рашиан хадны тамгат хавтангийн хэвийг авч, хуулбар хийн хадгалах	Хэв авч, хуулбар хийгдсэн байдал	БСШУСЯ	СҮГ, СӨҮТ	2020	13,000	13,000
24		2.1.3. Дундговь аймгийн Өлзийт сумын нутагт орших Дэл уулын хадны зургийн дардсыг авч хадгалах	Дардас авч хадгасан байдал	БСШУСЯ	СҮГ, СӨҮТ	2019	12,000	12,000
24		2.1.4. Архангай аймгийн Тариат сумын нутагт орших Дадгын өвөлжөөний хүн чулуун хөшөөний хэвийг авч, хуулбар хийн хадгалах	Хэв авч, хуулбар хийгдсэн байдал	БСШУСЯ	СҮГ, СӨҮТ	2020	7,000	7,000
25		2.1.5. Булган аймгийн Могод сумын нутагт орших Хөл Асгатын хөшөөний хэвийг авч, хуулбар хийн хадгалах	Хэв авч, хуулбар хийгдсэн байдал	БСШУСЯ	СҮГ, СӨҮТ	2021	6,000	6,000

26	2.1.6. Булган аймгийн Орхон сумын нутагт орших Сээрийн адгийн 11-р буган чулуун хөшөөний хэвийг авч, хуулбар хийн хадгалах	Хэв авч, хуулбар хийгдсэн байдал	БСШУСЯ	СҮГ, СӨҮТ	2021	6,000	6,000	
27	2.1.7. Өвөрхангай аймгийн Есөнзүйл сумын нутагт орших Бууралын хун чулуун хөшөөний хэвийг авч, хуулбар хийн хадгалах	Хэв авч, хуулбар хийгдсэн байдал	БСШУСЯ	СҮГ, СӨҮТ	2022	7,000	7,000	
28	2.1.8. Өвөрхангай аймгийн Богд сумын нутагт орших Тэвш уулын хадны зургийн дардсыг авч хадгалах	Дардас авч хадгалсан байдал	БСШУСЯ	СҮГ, СӨҮТ	2022	15,000	15,000	
29	2.1.9. Сухбаатар аймгийн Дарьганга сумын нутагт орших Ламтын хун чулуудын хэвийг авч, хуулбар хийн хадгалах	Хэв авч, хуулбар хийгдсэн байдал	БСШУСЯ	СҮГ, СӨҮТ	2023	9,000	9,000	
30	2.1.10. Баянхонгор аймгийн Галуут сумын нутагт орших Бунхант хясааны бурхадын хөргийг цэвэрлэж бэхжүүлэх, дардас авч хадгалах	Дардас авч хадгалсан байдал	БСШУСЯ	СҮГ, СӨҮТ	2023	18,000	18,000	
31	2.1.11. Архангай аймгийн Ихтамир сумын нутагт орших Алтан сандал уулын буган чулуун хөшөөний хэвийг авч, хуулбар хийн хадгалах	Хэв авч, хуулбар хийгдсэн байдал	БСШУСЯ	СҮГ, СӨҮТ	2024	7,000	7,000	
32	2.1.12. Сухбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын нутагт орших Жаргалантын ширээнэ хадны зургийн дардсыг авч хадгалах	Дардас авч хадгассан байдал	БСШУСЯ	СҮГ, СӨҮТ	2019	9,000	9,000	
Нийт дүн						117,000	117,000	
33	2.2. Цэвэрлэж бэхжүүлэх, сэргээн засварлах;	2.2.1. Өвөрхангай аймгийн Хархорум сумын нутагт орших Хархорумын 1 дүгээр монгол бичээст гэрэлт хөшөөг сэргээн засварлах	Сэргээн засварласан байдал	БСШУСЯ	СҮГ, СӨҮТ	2019-2020	38,000	38,000
34		2.2.2. Булган аймгийн Сайхан сумын нутагт орших Могойн шинэ усны гэрэлт хөшөөг сэргээн засварлах	Сэргээн засварласан байдал	БСШУСЯ	СҮГ, СӨҮТ	2020-2021	25,000	25,000
35		2.2.3. Архангай аймгийн Ихтамир сумын нутагт орших Тайхар чулууны бичээсийг цэвэрлэж бэхжүүлэх	Цэвэрлэж бэхжүүлсэн байдал	БСШУСЯ	СҮГ, СӨҮТ	2020	13,000	13,000
36		2.2.4. Дорноговь аймгийн Иххэт сумын нутагт орших Хэсэг байцшинын гэрэлт хөшөөг сэргээн засварлах	Сэргээн засварласан байдал	БСШУСЯ	СҮГ, СӨҮТ	2021	30,000	30,000
37		2.2.5. Завхан аймгийн Шилүүстэй сумын нутагт орших Дааган дэлийн буган чулуун хөшөөдийг цэвэрлэж бэхжүүлэх	Цэвэрлэж бэхжүүлсэн байдал	БСШУСЯ	СҮГ, СӨҮТ	2022	10,000	10,000
38		2.2.6. Төв аймгийн Дэлгэрхан сумын нутагт орших Их хөшөөтийн дурсгалыг цэвэрлэж бэхжүүлэх, сэргээн засварлах	Сэргээн засварласан байдал	БСШУСЯ	СҮГ, СӨҮТ	2023	40,000	40,000
39		2.2.7. Өвөрхангай аймгийн Хархорин сумын нутагт орших мэлхий чулуудыг цэвэрлэж бэхжүүлэх	Цэвэрлэж бэхжүүлсэн байдал	БСШУСЯ	СҮГ, СӨҮТ	2020	16,000	16,000
Нийт дүн						172,000	172,000	-

40	2.3. Хамгаалалтын хайс, хашаа барьж, танилцуулга байрлуулах;	2.3.1. Архангай аймгийн Өндөр-Үлаан сумын нутагт орших Их Жартгалантын амны буган чуулун хөшөө бүхий цогцолбор	Хамгаалалтын хашаа барьж, танилцуулга байрлуулсан байдал	БСШУСЯ	СҮГ, СӨҮТ	2019	120,000	120,000	
41		2.3.2. Хөвсгөл аймгийн Бүрэнготгох сумын нутагт орших Ушигийн өврийн буган чуулун хөшөө бүхий цогцолбор	Хамгаалалтын хашаа барьж, танилцуулга байрлуулсан байдал	БСШУСЯ	СҮГ, СӨҮТ	2019	100,000	100,000	
42		2.3.3. Завхан аймгийн Шиллүүстэй сумын нутагт орших Дааган дэлгийн буган чуулун хөшөө бүхий цогцолбор	Хамгаалалтын хашаа барьж, танилцуулга байрлуулсан байдал	БСШУСЯ	СҮГ, СӨҮТ	2020	45,000	45,000	
43		2.3.4. Булган аймгийн Баян-Агт сумын нутагт орших Шивээт улааны цогцолбор	Хамгаалалтын хашаа барьж, танилцуулга байрлуулсан байдал	БСШУСЯ	СҮГ, СӨҮТ	2022	160,000	160,000	
44		2.3.5. Сүхбаатар аймгийн Дарьганга сумын нутагт орших Хөргийн хөндийн хүн чуулун хөшөө бүхий цогцолбор	Хамгаалалтын хашаа барьж, танилцуулга байрлуулсан байдал	БСШУСЯ	СҮГ, СӨҮТ	2021	80,000	80,000	
45		2.3.6. Хэнтий аймгийн Батширээт сумын нутагт орших Раашаан хадны цогцолбор дурсгал	Хамгаалалтын хашаа барьж, танилцуулга байрлуулсан байдал	БСШУСЯ	СҮГ, СӨҮТ	2020	100,000	100,000	
Нийт дүн							605,000	605,000	
46	2.4. Устах эрдэлд орсон дурсгалыг унаган газрас нь зөөх тээвэрээн үзүүлгүүг газарт шилжүүлэх байрлуулах;	2.4.1. Булган аймгийн Сайхан сумын нутагт орших Могойн шинэ усны гэрэлт хөшөө	Аюулгүй газарт шилжүүлсэн байдал	БСШУСЯ	СҮГ, СӨҮТ, МҮМ	2020	3,000	3,000	
47		2.4.2. Дорноговь аймгийн Иххэт сумын нутагт орших Хасаг байшинтын гэрэлт хөшөөний чуулун малхий	Аюулгүй газарт шилжүүлсэн байдал	БСШУСЯ	СҮГ, СӨҮТ, МҮМ	2021	3,500	3,500	
48		2.4.3. Сүхбаатар аймгийн Онгон сумын нутагт орших Шонх таван толгойн хүн чуулун хөшөө	Аюулгүй газарт шилжүүлсэн байдал	БСШУСЯ	СҮГ, СӨҮТ	2020	4,000	4,000	
49		2.4.4. Баян-Өлгий аймгийн Цэнгэл сумын Даяннуурын хүн чуулун хөшөө	Аюулгүй газарт шилжүүлсэн байдал	БСШУСЯ	СҮГ, СӨҮТ	2022	6,000	6,000	
50		2.4.5. Архангай аймгийн Хангай сумын Үрт жалгын буган чуулун хөшөө	Аюулгүй газарт шилжүүлсэн байдал	БСШУСЯ	СҮГ, СӨҮТ	2023	8,000	8,000	
Нийт дүн							24,500	24,500	
51	2.5. Чулуулгийн бутгийн болон эвдрэл гэмтгийг нарийвчлан судалж тодорхойлох лаборатори Бийнхүүк	2.5.1. Соёлын өвийн үндэсний төвд лаборатори байгуулах	Лабораторийн хүчин чадал	БСШУСЯ	СҮГ, СӨҮТ	2020	800,000		800,000

52	Чадлыгийн музейд чулгуулгийн эвдрэл гэмтлийг тодорхойлох бараж нийлуулэх	Нийлүүлсэн баражийн тоо	БСШУСЯ	СҮГ, СӨҮТ, Аймгийн музейд	2021	210,000		210,000
Нийт дүн						1,010,000		1,010,000
Зорилт 3.Чулуун соёлын өвийг сурталчлах;						1,048,000	1,048,000	
53	3.1. Баримтат кино бүтээжж сурталчлах;	3.1.1. "Нүүдэлчдийн буга эрхэмлэх зан үйл ба буган чулун хөшөө" сэдэвт шинжлэх ухааны баримтат кино бүтээх	Баримтат киноны чанар, хэмжээ	БСШУСЯ	СҮГ, СӨҮТ, TAX	2020	110,000	110,000
54		3.1.2. "Хадан дээрх зураг эртний нүүдэлчдийн ахуй" сэдэвт шинжлэх ухааны баримтат кино бүтээх	Баримтат киноны чанар, хэмжээ	БСШУСЯ	СҮГ, СӨҮТ, TAX	2021	130,000	130,000
55		3.1.3. "Нүүдэлчдийн бичиг угсийн соёл" танин мэдэхүйн баримтат кино бүтээх	Баримтат киноны чанар, хэмжээ	БСШУСЯ	СҮГ, СӨҮТ, TAX	2022	80,000	80,000
56		3.1.4. "Хүн чулууны хүүүрнээп" шинжлэх ухааны баримтат кино бүтээх	Баримтат киноны чанар, хэмжээ	БСШУСЯ	СҮГ, СӨҮТ, TAX	2023	120,000	120,000
Нийт дүн						440,000	440,000	-
57	3.2. Судалгаа, сурталчилгааны ном, бүтээн хэвлүүлэх;	3.2.1. "Монголын буган чулун хөшөө" судалгаа сурталчилгааны 3 боть бүтээлийг монгол, англи хэлээр хэвлүүлнэ.	Хэвлэгэдсэн бүтээлийн тоо	БСШУСЯ	СҮГ, СӨҮТ, TAX	2022	120,000	120,000
58		3.2.2. "Монголын хүн чулун хөшөө" судалгаа сурталчилгааны 2 боть бүтээлийг монгол, англи хэлээр хэвлүүлнэ.	Хэвлэгэдсэн бүтээлийн тоо	БСШУСЯ	СҮГ, СӨҮТ, TAX	2022	90,000	90,000
59		3.2.3. "Монголын хадны зураг" судалгаа сурталчилгааны 8 боть бүтээлийг монгол, англи хэлээр хэвлүүлнэ.	Хэвлэгэдсэн бүтээлийн тоо	БСШУСЯ	СҮГ, СӨҮТ, TAX	2022	250,000	250,000
60		3.2.4. "Монголын гэрэлт хөшөө, хадан дээрх бичээс" судалгаа сурталчилгааны 2 боть бүтээлийг монгол, англи хэлээр хэвлүүлнэ.	Хэвлэгэдсэн бүтээлийн тоо	БСШУСЯ	СҮГ, СӨҮТ, TAX	2022	70,000	70,000
Нийт дүн						530,000	530,000	
61	3.3. Тусгай үзэсгэлэн зохион байгуулах	3.3.1. "Дэл уулын хадны зураг" тусгай үзэсгэлэн зохион байгуулах	Зохион байгуулагдсан үзэсгэлэнгийн чанар	БСШУСЯ	СҮГ, СӨҮТ, MYM	2021	30,000	30,000
62		3.3.2. "Тэвш уулын хадны зураг" тусгай үзэсгэлэн зохион байгуулах	Зохион байгуулагдсан үзэсгэлэнгийн чанар	БСШУСЯ	СҮГ, СӨҮТ, MYM	2022	30,000	30,000
63		3.3.3. "Монголын чулуун соёлын өв" тусгай үзэсгэлэн зохион байгуулах	Зохион байгуулагдсан үзэсгэлэнгийн чанар	БСШУСЯ	СҮГ, СӨҮТ, MYM	2023	18,000	18,000
Нийт дүн						78,000	78,000	

Зорилт 4.Чулуун сөйлөн өвийг түшиглэсэн аялал жуулчлалын шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгох;						20,938,000	238,000	20,800,000	
64	4.1. хөтөч, тайлбарлагчийн чулуун сөйлөн өвийн талаарх мэдлэгийг дээшшуулэх	4.1.1. Хөтөч тайлбарлагчдад зориулсан сургалт зохион байгуулах	Сургалтад хамрагдсан хүний тоо	БСШУСЯ, БОАЖЯ	БОАЖЯ, СҮГ	2019	18,000	18,000	
65		4.1.2. Хөтөч тайлбарлагчдад зориулсан хялбаршуулсан гарын авлага хэвлэж түгээх	Түгээсэн гарын авлагын тоо	БСШУСЯ, БОАЖЯ	БОАЖЯ, СҮГ	2020	20,000	20,000	
Нийт дүн						38,000	38,000	-	
66	4.2. Зарим томоохон цогцолбор дурсгалыг түшиглэн музей, ил үзвэрийн газар байгуулах;	4.2.1. Төв аймгийн Эрдэнэ сумын нутагт орших Тонькуукын цогцолборт ил музей байгуулах	Музей байгуулагдсан байдал	БСШУСЯ, БОАЖЯ	БОАЖЯ, СҮГ, TAX	2019-2020	8,000,000	8,000,000	
67		4.2.2. Архангай аймгийн Хашаат сумын нутагт орших "Хөшөө цайдам" музейн барилга байгууламжийг шинэчилэх	Музей байгуулагдсан байдал	БСШУСЯ, БОАЖЯ	БОАЖЯ, СҮГ, TAX	2020-2023	12,000,000	12,000,000	
68		4.2.3. Хэнтэй аймгийн Батшиэрээт сумын нутагт орших Рашаан хадны дурсгалд ил музей байгуулах	Музей байгуулагдсан байдал	БСШУСЯ, БОАЖЯ	БОАЖЯ, СҮГ, TAX	2021-2022	800,000	800,000	
Нийт дүн						20,800,000.0		20,800,000.0	
69	4.3.Чулуун дурсгалыг түшиглэсэн аяллын маршрут бий болгох хөгжүүлэх.	Тусгай хамгаалалттай газарт орших чулуун дурсгалыг түшиглэсэн аяллын маршрут бий болгох	Шинээр бий болгосон маршрутын тоо	БСШУСЯ, БОАЖЯ	СҮГ, СӨҮТ, УТХГХ3	2020	20,000	20,000	
70		Аяллын маршрутуудыг тэмдэгжүүлж, тохижуулах	Тэмдэгжүүлж, тохижуулсан маршрутын тоо	БСШУСЯ, БОАЖЯ	СҮГ, СӨҮТ, УТХГХ3	2021	80,000	80,000	
Нийт дүн						100,000.0	100,000.0		
<b>БҮҮД ДҮН</b>						24,298,000.0	2,588,000.0	21,810,000.0	

Төвчилсан угийн тайлан:  
БСШУСЯ - Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам  
БОАЖЯ - Байгаль орчин, аялал жуулчлалын яам  
СҮГ - Соёл, урлагийн газар  
СӨҮТ - Соёлын өвийн үндэсний төв  
УТХГХ3 - Улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргаа  
ТАХ - Тух, археологийн хурэлзэн  
МУМ - Монголын Үндэсний музей  
ТББ - Төрийн бус байгууллага  
ЮМҮК - Юнескогийн Монголын Үндэсний комисс